

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ЧАНДМАНЬ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/68/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Гэрээт аудитор: Д.Нарантуул Утас: 70432545 цахим хаяг: Narantuul.d@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>ТБОНӨХБАҮХАТ</i>	<i>Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай</i>
<i>ЭМДС</i>	<i>Эрүүл мэндийн даатгалын сан</i>
<i>ЭМЯ</i>	<i>Эрүүл мэндийн яам</i>
<i>УТХО</i>	<i>Улсын төсвийн хөрөнгө оруулалт</i>
<i>ОНХС</i>	<i>Орон нутгийн хөгжлийн сан</i>

Агуулга

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /төгрөгөөр/	5
2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/	6
2.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /төгрөгөөр/	8
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	9
/төгрөгөөр/.....	9
2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/	10
2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН	11
3.АУДИТЫН ТАЙЛАН	12
3.1. Ерөнхий зүйл	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.9. Аудитын илрүүлэлт	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил...Error! Bookmark not defined.	
Аудитын зөвлөмж:	
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	17
.....	
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	19

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2021-02-25 № 2/125
танай _____ -ны № _____ -Т

ЧАНДМАНЬ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ ЭМЧ
Т.МЯТАВСҮРЭН ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Чандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг түлхүү хүргэж, эрүүл амьдралын идэвхтэй хэв маягийг хэвшүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар үр дүн, хэрэгжилт, эмч эмнэлгийн ажилтны ёс зүйн байдал зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

021020643

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЯДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>18,069,226.26</u>	<u>17,459,888.48</u>
33	АВЛАГА	442,198.66	818,893.42
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	232,985.66	609,679.98
335	Бусад авлага	209,213	209,213.44
3351	Байгууллагаас авах авлага	-	0.44
3352	Хувь хүмүүсээс авах авлага	209,213	209,213
35	БАРАА МАТЕРИАЛ	17,627,027.60	16,640,995.06
351	Түүхий эд материал	7,471,491.60	7,984,959.06
35130	Эм боох материал	7,471,491.60	7,984,959.06
354	Хангамжийн материал	9,480,536	6,476,036
35410	Бичиг хэргийн материал	265,900	767,550
35420	Аж ахуйн материал	593,000	-
35460	Хүнсний материал	1,588,736	176,316
35470	Бусад хангамжийн материал	7,032,900	5,532,170
35600	Мал амьтад	675,000	2,180,000
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>448,557,422.34</u>	<u>1,382,393,571.23</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	448,557,422.34	1,382,393,571.23
391	Газар		
392	Биет хөрөнгө	433,354,422.34	1,367,304,821.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	355,477,047	1,314,272,785
39202	Хуримтлагдсан элэгдэл	(13,869,253.40)	(89,899,845.68)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	81,176,787	107,938,987
39204	Хуримтлагдсан элэгдэл	(56,051,041.30)	(47,544,594.99)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	105,180,831	111,547,681
39206	Хуримтлагдсан элэгдэл	(59,789,655.72)	(65,126,735.50)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	50,064,093	68,406,818
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,884,385.24)	(32,340,273.52)
39217	Ном	50,000	50,000
393	Биет бус хөрөнгө	15,203,000	15,088,749.92
39301	Програм хангамж	732,000	732,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(275,000)	(389,250.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	14,746,000	14,746,000
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>466,626,648.60</u>	<u>1,399,853,459.71</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>9,072,912</u>	<u>3,155,278.03</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,072,912	3,155,278.03
413	Өглөг	9,072,912	3,155,278.03
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	831,513	492,513.33
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	7,588,899	2,500,000.00
4136	Бусад өглөг	652,500	162,764.70
41361	Байгууллагад төлөх өглөг	652,500	162,764.70

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	457,553,736.60	1,396,698,181.68
51	Засгийн газрын хувь оролцоо	457,553,736.60	1,396,698,181.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
		214,581,860.80	214,581,860.80
51101	Өмч: - төрийн	214,581,860.80	214,581,860.80
512	Хуримтлагдсан үр дүн	(84,473,231.48)	855,333,527.45
51210	Өмнөх үеийн үр дүн	(84,473,231.48)	(83,810,917.63)
51220	Тайлант үеийн үр дүн	-	939,144,445.08
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	327,445,107.28	326,782,793.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	466,626,648.60	1,399,853,459.71

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	410,810,824	1,479,336,184
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,295,544	1,035,393,378
120	Нийтлэг татварын бус орлого	24,295,544	1,033,399,378
120001	Хувьцааны ногдол ашиг	240,500	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,796,844	1,033,140,878
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	23,796,844	1,033,140,878
120009	Бусад орлого	258,200	258,500
122	Тусламжийн орлого	-	1,994,000
122001	Хандив тусламж /дотоод/	-	1,994,000
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	386,515,280	443,942,806
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	349,845,900	368,244,000
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	349,845,900	368,244,000
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	11,535,860
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	11,535,860
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	14,169,200	27,985,900
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	14,169,200	26,985,900
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	1,000,000
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	22,500,180	36,177,046
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	5,148,662
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	22,500,180	31,028,384
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	405,158,829.94	539,516,738.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	404,973,829.94	539,516,738.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	404,487,229.94	534,368,076.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	261,358,590	295,844,437
210101	Үндсэн цалин	210,628,741	205,750,399.42
210102	Нэмэгдэл	25,360,210	67,284,348.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,011,000	5,233,353
210104	Урамшуулал	20,358,639	17,576,335.67

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,308,123.79	37,693,132.58
210201	Тэтгэврийн даатгал	23,620,980.19	25,910,862.07
210202	Тэтгэмжийн даатгал	2,688,585.90	3,048,336.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,132,948.72	2,421,869.36
210204	Ажилгүйдлийн даатгал	533,237.18	573,824.04
210205	Эрүүл мэндийн даатгал	5,332,371.80	5,738,240.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,456,470	26,082,100
210301	Гэрэл, цахилгаан	1,846,500	1,900,700
210302	Түлш, халаалт	12,173,570	23,850,900
210303	Цэвэр, бохир ус	436,400	330,500
2104	Хангамж, бараа материалын зардал	26,212,240	24,818,979
210401	Бичиг хэрэг	2,631,100	2,323,879
210402	Тээвэр, шатахуун	20,510,100	18,992,600
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,525,000	1,502,700
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,264,100	564,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	126,300	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	155,640	1,435,800
2105	Нормативт зардал	37,468,647.95	42,954,128.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,527,143.95	29,665,428.10
210502	Хоол, хүнс	6,941,504	9,832,700
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	3,456,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	390,000	381,500
210601	Багаж, техник, хэрэгсэл	40,000	264,000
210604	Урсгал засвар	350,000	117,500
2107	Томилолт, зочны зардал	1,611,000	540,000
210702	Дотоод албан томилолт	1,611,000	540,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	880,000	1,514,425.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,023,930.83
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000	270,000
210803	Даатгалын үйлчилгээ	-	81,675
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	69,300
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	680,000	69,519.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,802,158.20	104,539,374.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,263,620.00	12,459,785.50
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,538,538.20	92,079,589.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	486,600	5,148,662
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	5,148,662
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	5,148,662
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	446,900	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	446,900	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	39,700	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,700	-

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	185,000	-
2200	Дотоод эх үүсвэрээр	185,000	-
223001	Бусад хөрөнгө	185,000	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	5,651,994.06	939,819,445.08
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	675,000
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		675,000
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(675,000)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	5,651,994.06	939,144,445.08

2.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	387,425,980	443,656,881
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	258,200	258,500
120	Нийтлэг татварын бус орлого	258,200	258,500
120009	Бусад орлого	258,200	258,500
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	387,167,780	443,398,381
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	349,845,900	368,244,000
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	349,845,900	368,244,000
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	11,535,860
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	11,535,860
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	14,821,700	27,441,475
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	14,821,700	26,441,475
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	1,000,000
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	22,500,180	36,177,046
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	5,148,662
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	22,500,180	31,028,384
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	387,425,980	443,656,881
21	УРСГАЛ ЗАРДАЛ	387,425,980	443,656,881
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	386,939,380	438,008,219
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	248,263,684	288,125,700
210101	Үндсэн цалин	173,432,484	198,031,663.02
210102	Нэмэгдэл	56,213,941	67,284,348.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,439,259	5,233,353
210104	Урамшуулал	12,178,000	17,576,335.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,049,195	38,627,000
210201	Тэтгэврийн даатгал	21,038,800	27,181,900
210202	Тэтгэмжийн даатгал	3,603,085	2,861,300
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,980,100	2,289,000
210204	Ажилгүйдлийн даатгал	494,800	572,300
210205	Эрүүл мэндийн даатгал	4,932,410	5,722,500
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,682,900	25,857,100
210301	Гэрэл, цахилгаан	1,846,500	1,675,700

210302	Түлш, халаалт	11,400,000	23,850,900
210303	Цэвэр, бохир ус	436,400	330,500
2104	Хангамж, бараа материалын зардал	27,077,600	24,730,800
210401	Бичиг хэрэг	2,400,000	2,482,675
210402	Тээвэр, шатахуун	20,614,500	18,950,800
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,553,100	1,547,325
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,510,000	1,750,000
2105	Нормативт зардал	35,473,590.55	37,420,160
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,873,890.55	26,420,160
210502	Хоол, хүнс	8,099,700	7,500,000
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,500,000	3,500,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,476,300	4,476,300
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,126,300	4,000,000
210604	Урсгал засвар	350,000	476,300
2107	Томилолт, зочны зардал	1,800,000	658,284
210702	Дотоод албан томилолт	1,800,000	658,284
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,888,910.45	9,148,675
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,688,910.45	8,290,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000	270,000
210803	Даатгалын үйлчилгээ	-	81,675
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	77,000
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,000,000	430,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,227,200	8,964,200
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,227,200	8,964,200
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	486,600	5,648,662
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	5,648,662
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	5,148,662
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	500,000
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	446,900	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	446,900	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	39,700	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,700	-

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	214,581,860.8	327,445,107.28	(90,069,725.54)	451,957,242.54
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	214,581,860.8	327,445,107.28	(90,069,725.54)	451,957,242.54
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	5,596,494.06	5,596,494.06

C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	214,581,860.8	327,445,107.28	(84,473,231.48)	457,553,736.6
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	214,581,860.8	327,445,107.28	(84,473,231.48)	457,553,736.6
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	662,313.85	662,313.85
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	214,581,860.8	327,445,107.28	(83,810,917.63)	458,216,050.45
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(662,313.85)	-	(662,313.85)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	939,144,445.08	939,144,445.08
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	214,581,860.8	326,782,793.43	855,333,527.45	1,396,698,181.68

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	393,713,800	386,939,380	425,036,200	424,373,859
21	УРСГАЛ ЗАРДАЛ	393,713,800	386,939,380	425,036,200	424,373,859
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	393,713,800	386,939,380	424,536,200	423,873,859
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	247,515,400	248,263,684	286,125,700	286,125,700
210101	Үндсэн цалин	172,684,200	173,432,484	195,691,100	196,031,663.02
210102	Нэмэгдэл	56,845,200	56,213,941	65,759,500	67,284,348.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,808,000	6,439,259	5,808,000	5,233,353
210104	Урамшуулал	12,178,000	12,178,000	18,867,100	17,576,335.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,939,400	32,049,195	38,627,000	38,627,000
210201	Тэтгэврийн даатгал	21,038,800	21,038,800	27,181,900	27,181,900
210202	Тэтгэмжийн даатгал	2,475,200	3,603,085	2,861,300	2,861,300
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,980,100	1,980,100	2,289,000	2,289,000
210204	Ажилгүйдлийн даатгал	495,000	494,800	572,300	572,300
210205	Эрүүл мэндийн даатгал	4,950,300	4,932,410	5,722,500	5,722,500
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,692,900	13,682,900	26,509,600	25,857,100
210301	Гэрэл, цахилгаан	1,846,500	1,846,500	2,062,300	1,675,700
210302	Түлш, халаалт	11,400,000	11,400,000	23,850,900	23,850,900
210303	Цэвэр, бохир ус	446,400	436,400	596,400	330,500
2104	Хангамж, бараа материалын зардал	27,850,800	27,077,600	24,820,800	24,730,800
210401	Бичиг хэрэг	2,400,000	2,400,000	2,400,000	2,482,675
210402	Тээвэр, шатахуун	20,950,800	20,614,500	18,950,800	18,950,800
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000	1,553,100	1,720,000	1,547,325
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000	2,510,000	1,750,000	1,750,000
2105	Нормативт зардал	38,000,000	35,473,591	27,934,300	27,934,300
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26,000,000	23,873,891	16,934,300	16,934,300

210502	Хоол, хүнс	8,500,000	8,099,700	7,500,000	7,500,000
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,500,000	3,500,000	3,500,000	3,500,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,476,300	4,476,300	4,476,300	4,476,300
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000	4,126,300	4,000,000	4,000,000
210604	Урсгал засвар	476,300	350,000	476,300	476,300
2107	Томилолт, зочны зардал	1,800,000	1,800,000	668,100	658,284
210702	Дотоод албан томилолт	1,800,000	1,800,000	668,100	658,284
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,123,300	15,888,910	9,058,700	9,148,675
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,923,300	14,688,910	8,200,000	8,290,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000	200,000	200,000	270,000
210803	Даатгалын үйлчилгээ	-	-	81,700	81,675
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	-	77,000	77,000
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,000,000	1,000,000	500,000	430,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,315,700	8,227,200	6,315,700	6,315,700
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,315,700	8,227,200	6,315,700	6,315,700
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-	500,000	500,000
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-	500,000	500,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-	500,000	500,000
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	393,713,800	387,167,780	424,928,100	424,373,859
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	349,846,400	349,845,900	368,244,000	368,244,000
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	349,846,400	349,845,900	368,244,000	368,244,000
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	14,169,200	14,821,700	26,985,900	26,441,475
132001	Орон нутгийн төсвөөс	14,169,200	14,821,700	26,985,900	26,441,475
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	29,698,200	22,500,180	29,698,200	29,688,384
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	29,698,200	22,500,180	29,698,200	29,688,384
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23	24	24	24
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	17	18	18	18
620003	Үйлчлэх ажилтан	4	4	4	4
620004	Гэрээт ажилтан	1	1	1	1
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	23	24	24	24
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	18	19	19	19
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	5	5

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он
------------	----------	----------

I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,500,000
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,500,000
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,500,000
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,500,000
210102	Нэмэгдэл	3,500,000
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,500,000
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,500,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,500,000

3.АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Чандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эрхлэгч их эмч Т.Мятавсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд хөтөлбөр арга хэмжээний болон шатахууны зарцуулалт, Шилэн данс хөтлөлтийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 22-нээс 2021 оны 02 дугаар сарын 24-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нарантуул хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Чандмань сумын Эрүүл мэндийн төв нь “Ард иргэдэд эрүүл аж төрөх ёсыг дадал хэвшил болгосон, нотолгоонд суурилсан, анхан шатны тусламж үйлчилгээг аюулгүй, чанартай үзүүлэхэд оршино” гэсэн зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

Чандмань сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэл нь төв хөдөөгийн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх байдлаар тодорхойлжээ.

Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Чандмань сумын Эрүүл мэндийн төв нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар 2020 оны санхүүгийн баримтад дотоод хяналт хийгдээгүй, аймгийн Төрийн сангаас өдөр тутмын хяналт хэрэгжүүлсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 410570.3 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 4105.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогоос 1479336.2 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 14793.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Чандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 933226.9 мянган төгрөгөөр буюу 200 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, өр төлбөр, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцооны данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Авлага	442.2	818.9	376.7
Бараа материал	17,627.0	16,641.0	(986.0)
Үндсэн хөрөнгө	448,557.4	1,382,393.6	933,836.2
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	466,626.6	1,399,853.5	933,226.9
Богино хугацаат өр төлбөр	9,072.9	3,155.3	(5,917.6)
Цэвэр хөрөнгө, өмч	457,553.7	1,396,698.2	939,144.5
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	466,626.6	1,399,853.5	933,226.9

Авлага дансны үлдэгдэл 818.9 мянган төгрөг болж 376.7 мянган төгрөгөөр өссөн шалтгаан нь ҮЭ-ийн татвар илүү төлсөнтэй холбоотой нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 16641.0 мянган төгрөг болж 986.0 мянган төгрөгөөр буурсан нь эм, боох материалыг өмнөх оны үлдэгдлээс зарцуулснаас шалтгаалсан байна.

№	Үзүүлэлт	Дүн
1	Оны эхний үлдэгдэл	17,627.02
2	Нэмэгдсэн	72,274.75
2.1	Худалдан авсан	60,555.61

2.2	Хандиваар	11,719.14
3	Хасагдсан	73,260.78
3.1	Худалдсан, зарцуулсан	73,260.78
4	Эцсийн үлдэгдэл	16,640.99

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 607426.8 мянган төгрөг, оны эцэст 1617694.3 мянган төгрөг болж 1010267.5 мянган төгрөгөөр өссөн нь 2019 онд УТХО-оор сумын ЭМТ-ийн барилга 958795.7, сумын ОНХС-аас 18600.0 тавилга эд хогшил, ЭМЯамны хөрөнгө оруулалтаар 40320.0 мянган төгрөгийн автомашин, мотоцикл, үнэ төлбөргүй, хандиваар 5700.0, төсвийн хөрөнгөөр 2500.0 мянган төгрөгөөр хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппарат худалдан авсан нийт 1025915.7 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна. .

№	Үзүүлэлт	Дүн
1	Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	607,426.8
2	Нэмэгдсэн	1,025,915.74
2.1	Худалдан авсан	2,500.0
2.2	Хандиваар	1,023,415.7
3	Хасагдсан	15,648.22
3.1	Акталсан	15,648.22
4	Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,617,694.3
6	Хуримтлагдсан элэгдлийн оны эхний үлдэгдэл	158,869.33
801	Элэгдлийн зардал тайлант хугацааны	92,079.59
	Дансны хасалт	15,648.22
10	Хуримтлагдсан элэгдлийн эцсийн үлдэгдэл	235,300.70
11	Үлдэгдэл өртөг	1,382,393.58

Өр төлбөр оны эхэнд 9702.9 мянган төгрөг оны эцэст 3155.3 мянган төгрөг болж 5917.6 мянган төгрөгөөр буюу 65 хувиар буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1396698.2 мянган төгрөг болж 939144.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд ашигтай ажилласантай холбоотой байна.

Чандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 83249.3 мянган төгрөгөөр буюу 22.7 хувиар өссөн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1068525.5 мянган төгрөгөөр буюу 260.1 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 18398.1 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт, 12816.7 мянган төгрөгөөр орон нутгийн санхүүжилт, нэмэлт орлого 11535.9, бусад орлого 19438.1 мянган төгрөгөөр, ЭМДС-аас авах санхүүжилт 8528.2, үнэ төлбөргүй орлого 1009344.4 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	410,810.8	1,479,336.3	1,068,525.5
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	24,055.0	1,033,399.4	1,009,344.4
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	349,845.9	368,244.0	18,398.1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	14,169.2	26,985.9	12,816.7
Хандив тусламжийн орлого	240.5	1,994.0	1,753.5
Нэмэлт санхүүжилтийн орлого		11,535.9	11,535.9
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		1,000.0	1,000.0

Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		5,148.7	5,148.7
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	22,500.2	31,028.4	8,528.2

Нийт зардал өмнөх оноос 134357.9 мянган төгрөгөөр буюу 33.2 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, урсгал шилжүүлэг, нормативт зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд тус тус өссөн, хангамж бараа материалын зардал, томилолтын болон хөрөнгийн зардлууд буурсан байна. Энэ нь Засгийн газрын 472 тоот тогтоолоор цалингийн сүлжээ, хэмжээ өөрчлөгдсөн холбоотой байна.

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		405,158.8	539,516.7	134,357.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	261,358.6	295,844.4	34,485.8
2102	Ажил олгогчоос даатгалд төлөх	34,308.1	37,693.1	3,385.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,456.5	26,082.1	11,625.6
2104	Хангамж, бараа материалын зардал	26,212.2	24,819.0	(1,393.2)
2105	Нормативт зардал	37,468.6	42,954.1	5,485.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	390.0	381.5	(8.5)
2107	Томилолт, зочны зардал	1,611.0	540.0	(1,071.0)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	880.0	1,514.4	634.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,802.2	104,539.4	76,737.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	486.6	5,148.7	4,662.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	185		-185

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 442888.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 442888.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөр, 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 424928.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 368244.0 мянган төгрөгийг тусгай шилжүүлгийн санхүүжилтээс, 26985.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, ЭМД-ын сангаас 29698.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай шилжүүлгийн санхүүжилтээс 368244.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 26441.5 санхүүжилт, ЭМД-ын сангаас 29688.4 мянган төгрөг авч, нийт 424373.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 424373.9 мянган төгрөгийг зарцуулж 544.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс дутуу санхүүжилт авсан нь өмнөх онд илүү авсан санхүүжилтээ суутган тооцсон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 434373.9 мянган төгрөг буюу 99.8 хувьтай зарцуулсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээ 544.4 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Хэмнэсэн шалтгаан нь 544.4 мянган

төгрөгөөр орон нутгийн төсвөөс авах санхүүжилтээ суутган тооцоо хийсэнтэй холбоотой байна. Хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 3	Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт	/мян.төг/
код	хөтөлбөр, арга хэмжээ	мөнгөн дүн
80109	ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	544.4
	ДҮН	544.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансаар ЭМГ-аас эмийн зардлын санхүүжилт 11825.9, сорьц тээвэр шатахуунд 258.5, аймгийн Засаг даргын хөрөнгөөс 552.2 бүгд 11802.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 11211.5 мянган төгрөгийн эмийн зардалд зарцуулж, оны эцэст сумын ерөнхий орлогын дансанд 591.4 мянган төгрөгийг татан төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс, хугацаандаа оруулсан 145 мэдээллийг оруулсан, 1 хугацаа хоцроосон мэдээлэл байршуулж, Шилэн дансны мэдээллийг хянахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилт, дараа жилийн төсвийн төсөл, аудитын зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	89,668.4	2	89,668.4	-	-	100
Нийт дүн	2	89,668.4	2	89,668.4	-	-	100

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 163333.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 139021.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 24312.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө

Залруулсан алдаа: Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Санхүүгийн программд бараа материалыг зарлагадахдаа зардлын кодыг буруу сонгон 1640.0 мянган төгрөгийг бүртгэсэн,
2. Санхүүгийн үр дүнгийн тайланд орлого 5957.8 мянган төгрөгөөр дутуу тусгасан,
3. Өглөг 2500.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
4. Байгууллагын данс бүртгэлд байгаа мал амьтдыг үнэлгээг 1505.0 мянган төгрөгөөр дутуу,
5. Тайлант онд үнэ төлбөргүй шилжүүлэн ирсэн 5420.0 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авч бүртгээгүй,
6. Хөрөнгийн элэгдлийн зардал 64902.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
7. Акталсан хөрөнгийн дахин үнэлгээний бууралтыг 662.3 мянган төгрөгөөр бичээгүй,
8. Тайлант үеийн үр дүнг 56433.9 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэснийг аудитын явцад залруулга хийгдлээ.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 139021.2 мянган төгрөгийн залруулга хийж, залруулсан албан тоот ирүүлсэн болно.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 24312.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар авч үзэх нь асуудалгүй болно.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.Өглөгийн данстай холбоотой асуудал

- 1.1. **Илрүүлэлт:** Хөтөлбөр арга хэмжээний зардалд 3985.7 мянган төгрөгийг зарцуулахдаа сургалт хийх тухай удирдамж батлуулан төлбөрийг төлсөн, гүйцэтгэлийн тайлангүй сургалтад хэчнээн хүн оролцсоныг нотлох анхан шатны баримтгүй, сургалтад зарцуулсан хөрөнгийн үр өгөөж хангалтгүй байна.
- 1.2. **Эрсдэл:** Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, сургалт зохион байгуулаагүй байх,

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", гэсэн заалтуудыг мөрдөх, дотоод хяналтыг хэрэгжүүлэх ажиллах

- 1.3. **Байгууллагаас өгсөн хариу:** Хүлээн зөвшөөрсөн.

2. Шатахууны зарцуулалттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Тайлант онд нийт 18950.8 мянган төгрөгийн шатахуун худалдан авч шатахууны нягтлан бодогч нь жолоочийн тооцоо бодоогүй, алсын дуудлагын журналтай тулгахад дуудлагын журналд бүртгэлгүй дуудлагад шатахуун олгосон, шатахуун олгох зөвшөөрлийн бичиг дугааргүй, эд хариуцагчийн тайлан гаргаагүй, зарцуулалтад тавих дотоод хяналт хэрэгжүүлээгүй дутагдал илэрлээ.

2.2. Эрсдэл: Бүртгэлгүй дуудлагад шатахуун олгох, хяналтгүйгээс хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах.

2.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 15-д Хариуцаж байгаа эд зүйлийг зохих хууль ёсны баримт материал бүрдсэн буюу удирдлагын шийдвэрээр зориулагдсан зүйлд нь өөрийн биеэр тавьж олгож, хяналт тавьж ажиллана, Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 17-д Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид өгч байна" гэсэн заалтыг хэрэгжүүлэн сар бүрийн шатахууны тайлан гаргаж хэвших, дуудлагын журнал хөтлөх

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

3. Цалин, ажил хавсарсны нэмэгдэл олгосонтой холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Тайлант онд батлагдаагүй орон тоонд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл олгосон, эмчлэгч эмчийг цалинжуулахдаа цалингийн зэрэглэл шатлал буруу мөрдөж сар бүрийн цалин амралтыг илүү тооцож 1376.1 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

2.2. Эрсдэл: Төсөв хэтрэх, эмч ажилчдад ур чадварын нэмэгдэл олгохгүй байх,

2.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Засгийн газрын 2019 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын "Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл" гэсэн заалтуудыг мөрдөх, батлагдаагүй орон тоонд ажил хавсарсны нэмэгдэл олгохгүй байх,

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Эмчлэгч эмчийг цалинжуулахдаа цалингийн зэрэглэл шатлал буруу мөрдөж сар бүрийн цалин амралтыг илүү тооцож олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Эрх ба үүрэг, Оршин байх, Тохиолдсон байх, Үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Засгийн газрын 2019 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын "Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлүүлэх төлбөрийн акт бичих

4. Шилэн данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг shilendans.gov.mn цахим сайтад дараа жилийн төсвийн төсөл, аудитын зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга

хэмжээ, 5 сая төгрөгөөс дээш орлого буюу сар бүрийн санхүүжилт, нэмэлт данснаас эмийн үнэ төлсөн зарлагыг мэдээлээгүй зөрчил байна.

4.2. Эрсдэл: Мэдээллийн ил тод мэдээлээгүй байх, мэдээлэл дутуу байршуулах

4.3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын 4.2.14.-д "аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг жил бүрийн 7 дугаар сарын 1-ний дотор PDF форматаар", 3.1.16. дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор PDF форматаар" гэсэн заасны дагуу мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв мэдээлэх

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо: 2021	Аудитын нэр: Чандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ХОА-2021/68/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Чандмань сумын Эрүүл мэндийн төв	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
1	Санхүүгийн тайланд эм ороох боох материалын орлого илүү хасах тэмдэгтэй зарлагадаж үлдэгдэл дутуу тусгасан	1640.0	Залруулга хийх	Эрхлэгч эмч, нягтлан бодогч	Т.Мятавсүр эн, Ү.Тунгалагбаяр
2	Санхүүгийн үр дүнгийн тайланд орлого дутуу тусгасан	5957.8	Залруулга хийх		
3	Тайлант үеийн үр дүн зөрүүтэй илэрхийлсэн	56433.9	Залруулга хийх		
4	Байгууллагад өгөх өглөг зөрүүтэй тусгасан	2500.0	Залруулга хийх		
5	Бараа материалын данс бүртгэлд байгаа мал амьтдын тооцоо хийгээгүй	1505.0	Залруулга хийх		
6	ЭМЯ -ны хөрөнгө оруулалтаар хуваарилсан хөрөнгө бүртгээгүй орхигдуулсан	5420.0	Залруулга хийх		
7	Тайлант онд хөрөнгө актлахдаа 2010 онд дахин үнэлэгдсэн хөрөнгийг данс бүртгэлээс хасахдаа дахин үнэлгээний нэмэгдлийг бууруулах бичилтийг орхигдуулсан	662.3	Залруулга хийх		
8	Тайлант оны элэгдлийн зардал зөрүүтэй тусгасан	64902.2	Залруулга хийх		

9	Нягтлан бодогч нь тайлант онд худалдан авсан шатахууны болон жолоочийн тооцоо бодоогүй, алсын дуудлагын журналтай тулгахад дуудлагын журналд бүртгэлгүй дуудлагад шатахуун олгосон, шатахуун олгох зөвшөөрлийн бичиг дугааргүй, эд хариуцагчийн тайлан гаргаагүй, зарцуулалтад тавих дотоод хяналт хэрэгжүүлээгүй	18950.8	Зөвлөмж өгөх	Эрхлэгч эмч, нягтлан бодогч	Т.Мятавсүр эн, Ү.Тунгалагб аяр
10	Хөтөлбөр арга хэмжээний зардалд 3985.7 мянган төгрөгийг зарцуулахдаа сургалт хийх тухай удирдамж батлуулан төлбөрийг төлсөн, гүйцэтгэлийн тайлангүй сургалтад хэчнээн хүн оролцсоныг нотлох анхан шатны баримтгүй, сургалтад зарцуулсан хөрөнгийн үр өгөөж хангалтгүй байна.	3985.7	Зөвлөмж өгөх	Эрхлэгч эмч, нягтлан бодогч	Т.Мятавсүр эн, Ү.Тунгалагб аяр
11	Батлагдаагүй орон тоонд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл олгосон, эмчлэгч эмчийг цалинжуулахдаа цалингийн зэрэглэл шатлал буруу мөрдөж сар бүрийн цалин амралтыг илүү тооцож 1376.1 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.		Зөвлөмж өгөх	Эрхлэгч эмч, нягтлан бодогч	Т.Мятавсүр эн, Ү.Тунгалагб аяр
12	Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг shilendans.gov.mn цахим сайтад дараа жилийн төсвийн төсөл, аудитын зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээ, 5 сая төгрөгөөс дээш орлого буюу сар бүрийн санхүүжилт, нэмэлт данснаас эмийн үнэ төлсөн зарлагыг мэдээлээгүй		Зөвлөмж өгөх	Эрхлэгч эмч, нягтлан бодогч	Т.Мятавсүр эн, Ү.Тунгалагб аяр
ДҮН		163333.9			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР